

# Нью баланс аудит ХХК

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

МӨРӨН  
2022 ОН

БАТЛАВ.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ..... А.ЭРДЭНЭБААТАР

2022 оны ... дүгээр сарын ....-ны өдөр

### НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**1.1 Аудитын нэр, код:** Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит, ХӨА-2023/141/НА-СТА-ТШЗ

**1.2 Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4 болон Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитортой байгуулсан 02 тоот гэрээний дагуу Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны цаглаврын хүрээнд санхүүгийн тайлангийн аудит хийнэ.

**1.3 Аудитын ажлын зорилго:** Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд чиглэнэ.

**1.4 Аудитын ажлын шинж чанар, хугацаа, хамрах хүрээ:** Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” 2022 оны А/75 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны А/15 тоот тушаалыг үндэслэн санал дүгнэлт гаргана.

Аудитыг аудитор Д.Гэрэлчулуун гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Б.Лхагвадорж, чанарын хяналтыг аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Аудитад 2022 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, анхан шатны баримт, үйл ажиллагааны тайлан болон бусад шаардлагатай баримтуудыг хамруулна.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дараах асуудалд анхаарал хандуулна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж, МУЕА-ын 2022 оны А/59 тоот тушаалаар баталсан бодлого чиглэлийн дагуу үнэлнэ.
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг тусгайлан авч үзэж, үр дүнг тооцно.

**1.5 Аудитын урьдчилсан үйл ажиллагааны үр дүн:** Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөхүйц гэдгийг тодорхойлж, аудитын баг Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрэмд заасан шаардлагууд болон үүрэг хариуцлагыг бүрэн ойлгож мэдэгдэл гаргасан бөгөөд ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдсэн болно.

Мөн аудитын ажлын захидлыг 2022 оны 11 дугаар сарын 09-ны өдрийн 02/01/39 дугаар албан бичгээр шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж талуудын хүлээх үүрэг, хариуцлага болон аудитын урьдчилсан нөхцөлүүдийг харилцан тохиролцох, аудит хийх багийг танилцуулах нээлтийн уулзалтыг хянан удирдах ажилтнуудын оролцоотой гүйцэтгэж тэмдэглэл хөтөлсөн.

МУЕА-ын 2020 оны А/93 дугаар тушаалаар баталсан “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам”-ыг уншиж танилцсан ба энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу нөлөөллийн мэдүүлгийг гаргаж, шалгагдч байгууллагын удирдлагад танилцуулан баталгаажуулсан болно.

**1.6 Төлөвлөх үе шатанд хийсэн ажлууд, тэдгээрийн үнэлгээ:** Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитыг төлөвлөх үе шатны ажлыг бүрэн гүйцэтгэж, аудитын ажлын баримт бэлтгэж, хянуулсан.

**1.6.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналтыг ойлгож эрсдэлтэй асуудлыг тодорхойлох:** Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:

1. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх /бие бялдрын, хэл яриан гоо зүйн гэх мэт/
2. Сургалт үйл ажиллагааны хэвийн байдал, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах
3. Хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх
4. Багшийн мэргэжлийн хөгжлийг хангах
5. Эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг хангах

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна. Үүнтэй холбогдуулан Засгийн газар болон Боловсрол шинжлэх ухааны яамнаас дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

1. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
2. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ” баталсан байна.
3. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
4. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх

хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон. Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Тус байгууллагад дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нэгж, ажилтан байхгүй байна.

**1.6.2 Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг тодорхойлох:** Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын дүн 400.4 сая төгрөгийг суурь үзүүлэлтээр сонгосон.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэлж, материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 8.0 сая төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Дээрх ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (80 хувиар) буюу 6.4 сая төгрөгөөр тогтоолоо.

Төлөвлөлтийн шатанд суурь үзүүлэлтийг өмнөх оны санхүүгийн тайлангийн дүнг ашигласан тул гүйцэтгэлийн шатанд материаллаг түвшинг шинэчлэн тооцох магадлал өндөр байна.

**1.6.3 Эрсдэлийн үнэлгээний үр дүн:** Байгууллага, түүний орчин, дотоод хяналтын талаар ойлголт авч, эрсдэлийн үнэлгээний горимыг үндэслэн санхүүгийн тайлангийн түвшинд, батламж мэдэгдлийн түвшинд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тодорхойлж, бүртгэсэн.

Тодорхойлсон эрсдэлүүдээс нөлөө бүхий эрсдэлийг эрэмбэлж, үнэлсэн бөгөөд түүний дотор хяналтын үйл ажиллагааг авч үзсэн.

Мөн ач холбогдолтой биш боловч материаллаг байж болзошгүй эрсдэлүүдийг бүртгэж шинж чанарын хувьд материаллаг эсэх, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд нөлөөлөх эсэхийг үнэлсэн.

Эрсдэлийн үнэлгээнээс хамаарч нөлөө бүхий 7 эрсдэл тодорхойлж бие даасан горим болон хяналтын сорил хэрэгжүүлэхээр баримтжуулав. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг Fas.audit.mn цахим системд оруулсан агуулгын хувьд тухайн байгууллагад холбогдолтой асуудлыг бүрэн хянаж ажиллахаар төлөвлөсөн болно.

Аудитын нөхцөл байдлаас хамаарч гүйцэтгэлийн шатанд шинээр эрсдэл нэмж тооцож болзошгүй байна.

**1.6.4 Үнэлсэн эрсдэлд өгөх ерөнхий хариу:** Үнэлсэн эрсдэлд өгөх ерөнхий хариуг зохиомжилж аудитыг гүйцэтгэх үе шатанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бие даасан горим болон хяналтын сорилд хамаарах батламж мэдэгдэл, стандартын

болон хууль тогтоомжтой холбоотой шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацааг тодорхойлов.

**1.6.5 Аудитын үр өгөөжийн урьдчилсан төлөвлөлт:** Санхүүгийн тайлангийн аудитаар 80.0 мянган төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болгохоор урьдчилан тооцоолж, шалгадагч байгууллагын үйл ажиллагаанд чанарын ахиц, дэвшил гарсныг санхүүгийн бус үр өгөөжөөр бүртгэхээр төлөвлөв.

**1.7 Санхүүгийн тайлангийн аудитад ашиглах нөөц:** Аудитад ашиглах нөөцийг дараах байдлаар тодорхойлов.

**1.7.1 Аудит хийх багийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүрэг:**

дд	Багийн гишүүдийн		Аудитын явцад гүйцэтгэх үүрэг
	Овог нэр	Албан тушаал	
1	А.Эрдэнэбаатар	Тэргүүлэх аудитор	Аудитыг хянан удирдах
2	Б.Тэгшдэлгэр	Аудитын менежер	Аудитын үе шатны хяналт хэрэгжүүлэх, арга зүйгээр хангах
3	Л.Мандахнаран	Аудитор	Аудитын үе шатны хяналт хэрэгжүүлэх, арга зүйгээр хангах
4	Б.Лхагвадорж	Партнер	Анхан шатны хяналтыг хэрэгжүүлэх
5	Д.Гэрэлчулуун	Ахлах аудитор	Аудитыг гүйцэтгэх

**1.7.2 Аудитад зарцуулах хугацаа, төсөв:**

д д	Багийн гишүүдийн		Аудитад зарцуулах хугацаа (хүн/өдөр)	Аудитад зарцуулах төсөв (мян.төг)			
	Овог нэр	Албан тушаал		Цалин	Томилолт	Бусад	Дүн
	1	2	3	4	5	6	7
1	Б.Лхагвадорж	Партнер	1/2	170.0	0	30.0	200.0
2	Д.Гэрэлчулуун	Ахлах аудитор	1/7	475.0	0	45.0	520.0
	Дүн		2/9	645.0	0	75.0	720.0

## ХОЁР. АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ҮЕ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОРИМ, СОРИЛ

Хэрэгжүүлэх горим, сорилууд		Аудитын горимын		
		Шинж чанар	Хугацаа	Хамрах хүрээ
<b>2.1 Санхүүгийн тайлангийн түвшинд</b>				
1	Шалгагдагч байгууллагаас бэлтгэн ирүүлсэн санхүүгийн тайлангийн иж бүрдэлд ажиглалт хийх	Хяналтын сорил	2023.01.15- 2023.2.25	2022 оны үйл ажиллагааг хамруулна
2	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг төсөв санхүүгийн анхан шатны баримттай тулган дахин хянах	Хяналтын сорил	2023.01.15- 2023.2.25	2022 оны үйл ажиллагааг хамруулна
<b>2.2 Батламж мэдэгдлийн түвшинд</b>				
1	Зардлын батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан эсэхийг гүйцэтгэлтэй тулган шалгах	Биет горим	2023.01.15- 2023.2.25	2022 оны үйл ажиллагааг нягтлах
2	Засгийн газрын 2019 оны 450 дугаар "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолын дагуу хүүхдийн хоолыг тооцож олгосон эсэхийг гүйцэтгэлтэй тулган шалгах	Биет горим	2023.01.15- 2023.2.25	2022 оны үйл ажиллагааг хамруулна
3	Бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэсэн эсэхийг бараа материалын тооллогын үлдэгдэлтэй тулган хянах	Биет горим	2023.01.15- 2023.2.25	2022 оны үйл ажиллагааг хамруулна
4	Тэтгэвэрт гарахад нь олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг бусад тэтгэмжтэй давхардуулан олгосон эсэхийг тушаал шийдвэр, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримт руу хөөн шалгах.	Биет горим	2023.01.15- 2023.2.25	2022 оны үйл ажиллагааг хамруулна
5	Үндсэн хөрөнгийн тооллогын үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгасан дүнтэй тулган шалгах	Биет горим	2023.01.15- 2023.2.25	2022 оны үйл ажиллагааг хамруулна
6	Байгууллагаас хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон эсэхийг мөнгөн хөрөнгийн журнал, анхан шатны баримт руу хөөн шалгах	Биет горим	2023.01.15- 2023.2.25	2022 оны үйл ажиллагааг хамруулна

## ГУРАВ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХӨТӨЛБӨР

№	Хийгдэх ажил	Зарцуулах өдөр /тоогоор/	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Хариуцах ажилтны албан тушаал, овог, нэр
	1	2	3	4	5
1	Аудитын урьдчилсан үйл ажиллагаа	1	2022.11.01	2022.11.16	Ахлах аудитор Д.Гэрэлчулуун

2	Аудитыг төлөвлөх	7	2022.11.16	2023.01.15	Ахлах аудитор Д.Гэрэлчулуун
3	Аудитыг гүйцэтгэх	3	2023.01.25	2023.02.06	Ахлах аудитор Д.Гэрэлчулуун
4	Дуусгавар болох ба дахин хянах	1	2023.01.28	2023.02.08	Ахлах аудитор Д.Гэрэлчулуун
5	Аудитыг тайлагнах	2	2023.01.29	2023.02.09	Ахлах аудитор Д.Гэрэлчулуун
6	Аудитын дараах үйл ажиллагаа	1	2023.02.25	2023.02.26	Ахлах аудитор Д.Гэрэлчулуун

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ  
ХЯНАСАН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР:

 /Б.ТЭГШДЭЛГЭР/ Огноо: 2/23

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН АУДИТОР:


 /Л.МАНДАХНАРАН/ Огноо: 1/23

НЬЮ-БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

 /Б.ЛХАГВАДОРЖ/ Огноо:

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

 /Д.ГЭРЭЛЧУЛУУН/ Огноо: 2023.01.09

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/141/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Нью-баланс аудит ХХК-ийн партнер Б.Лхагвадорж  
Утас: 99101901 Цахим хаяг: [newbalance.lhagvaa@gmail.com](mailto:newbalance.lhagvaa@gmail.com)  
Аудитор: Д.Гэрэлчулуун  
Утас: 99509636 Цахим хаяг: [d.gerlee98@gmail.com](mailto:d.gerlee98@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
Асуудлыг онцолсон хэсэг .....	4
Аудитын гол асуудал .....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	12
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС      Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт  
АДБОУС        Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Р. АМАРБАЯСГАЛАН ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.21 № 01/207  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээллийг оруулна.

2022 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 391,398.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 71,081.1 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 77,749.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 1,663.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлууд байна. Засаглах эрх бүхий этгээдийн түвшин дэх харилцаанаас аудитын гол асуудлыг сонгоно.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

### Бусад асуудлын хэсэг

Бусад асуудлын хэсэгт аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг оруулна.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Шинэ-Идэр сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, түүнийг 85 хувь биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А. ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>68,888,740.00</b>	<b>137,814,455.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	71,081,144.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	71,081,144.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	71,081,144.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	71,081,144.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	1,350,636.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,350,636.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	68,888,740.00	65,382,675.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	379,000.00	379,000.00
35130	Эм боох материал	379,000.00	379,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	68,509,740.00	65,003,675.00
35410	Бичиг хэргийн материал	57,500.00	00.00
35460	Хүнсний материал	8,706,650.00	9,504,900.00
35470	Бусад хангамжийн материал	59,745,590.00	55,498,775.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,326,907,335.68</b>	<b>2,282,545,231.59</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,326,907,335.68	2,282,545,231.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,319,799,335.56	2,275,492,231.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,493,552,216.79	2,493,552,216.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	-221,237,557.72	-268,722,909.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,792,553.00	41,940,063.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,377,008.30	-14,970,220.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,042,554.50	20,420,847.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,544,054.82	-9,307,408.70
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,373,468.00	20,373,468.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,146,945.89	-11,137,934.37
39217	Ном	3,344,110.00	3,344,110.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,108,000.12	7,053,000.16
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-164,999.88	-219,999.84
39303	Бусад биет бус хөрөнгө	6,998,000.00	6,998,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,395,796,075.68</b>	<b>2,420,359,686.59</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,395,796,075.68</b>	<b>2,420,359,686.59</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,395,796,075.68	2,420,359,686.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108,675,623.00	108,675,623.00
51101	Өмч: - төрийн	108,675,623.00	108,675,623.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,210,697,220.55	2,235,260,831.46
51210	Өмнөх үеийн үр дүн	2,210,697,220.55	2,210,697,220.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	24,563,610.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	76,423,232.13	76,423,232.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,395,796,075.68</b>	<b>2,420,359,686.59</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>378,884,935.50</b>	<b>483,860,852.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>26,686,869.50</b>	<b>14,712,952.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	26,686,869.50	14,712,952.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,686,869.50	14,712,952.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,686,869.50	14,712,952.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>56,488,966.00</b>	<b>469,147,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	391,398,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	391,398,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,709,100.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	778,166.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	778,166.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>55,710,800.00</b>	<b>77,749,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,710,800.00	77,749,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>400,392,659.80</b>	<b>459,297,241.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>400,392,659.80</b>	<b>459,297,241.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>386,767,521.80</b>	<b>457,633,695.59</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>226,060,330.00</b>	<b>256,052,005.00</b>
210101	Үндсэн цалин	226,060,330.00	256,052,005.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,710,919.00</b>	<b>32,528,215.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,503,419.00	22,180,913.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,301,900.00	2,573,125.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,841,500.00	2,113,299.71
210204	Ажилгүйдлийн даатгал	460,400.00	514,621.95
210205	Эрүүл мэндийн даатгал	4,603,700.00	5,146,254.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>50,328,263.00</b>	<b>53,555,554.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,449,181.00	3,336,481.00
210302	Түлш, халаалт	48,719,082.00	48,719,073.00
210303	Цэвэр, бохир ус	160,000.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,612,516.00</b>	<b>5,082,020.00</b>
210401	Бичиг хэрэг	345,100.00	57,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,850,000.00	2,088,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	778,166.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,489,250.00	2,936,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,159,330.00</b>	<b>34,753,180.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,144,900.00	42,380.00
210502	Хоол, хүнс	11,014,430.00	33,830,800.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	880,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,272,700.00</b>	<b>8,456,600.00</b>
210604	Урсгал засвар	2,272,700.00	8,456,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>56,000.00</b>	<b>112,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	56,000.00	112,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>836,900.00</b>	<b>315,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296,900.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	315,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>59,730,563.80</b>	<b>66,779,121.59</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,948,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,714,500.00	4,833,215.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,016,063.80	58,997,906.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,625,138.00</b>	<b>1,663,546.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>100,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,415,301.00</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,415,301.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,109,837.00</b>	<b>1,663,546.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,109,837.00	1,663,546.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-21,507,724.30</b>	<b>24,563,610.91</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-21,507,724.30</b>	<b>24,563,610.91</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>352,198,066.00</b>	<b>469,147,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>352,198,066.00</b>	<b>469,147,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	391,398,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	391,398,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,709,100.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>778,166.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	778,166.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>55,710,800.00</b>	<b>77,749,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,710,800.00	77,749,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>349,698,066.00</b>	<b>398,066,756.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>349,698,066.00</b>	<b>398,066,756.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>336,072,928.00</b>	<b>396,403,210.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>226,060,330.00</b>	<b>257,413,232.00</b>
210101	Үндсэн цалин	154,690,633.00	193,072,330.00
210102	Нэмэгдэл	54,339,900.00	51,202,500.00
210104	Урамшуулал	17,029,797.00	13,138,402.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,710,919.00</b>	<b>32,517,624.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,503,419.00	21,868,245.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,301,900.00	2,662,295.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,841,500.00	2,129,896.00
210204	Ажилгүйдлийн даатгал	460,400.00	532,398.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,603,700.00	5,324,790.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>50,328,263.00</b>	<b>53,555,554.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,449,181.00	3,336,481.00
210302	Түлш, халаалт	48,719,082.00	48,719,073.00
210303	Цэвэр, бохир ус	160,000.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,188,166.00</b>	<b>00.00</b>
210401	Бичиг хэрэг	222,600.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,850,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	778,166.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,187,400.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,476,050.00</b>	<b>34,551,900.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,200.00	00.00
210502	Хоол, хүнс	7,659,750.00	34,551,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	742,100.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,272,700.00</b>	<b>4,080,000.00</b>
210602	Тавилга	8,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,272,700.00	4,080,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>56,000.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	56,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>836,900.00</b>	<b>315,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296,900.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	315,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,143,600.00</b>	<b>13,969,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,000.00	8,719,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,968,600.00	5,250,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,625,138.00</b>	<b>1,663,546.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>100,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,415,301.00</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,415,301.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,109,837.00</b>	<b>1,663,546.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,109,837.00	1,663,546.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,500,000.00</b>	<b>71,081,144.00</b>

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,500,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,500,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,500,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,500,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2,500,000.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	71,081,144.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	71,081,144.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,675,623.00	76,423,232.13	2,210,697,220.55	2,395,796,075.68
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,675,623.00	76,423,232.13	2,210,697,220.55	2,395,796,075.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,675,623.00	76,423,232.13	2,210,697,220.55	2,395,796,075.68
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,563,610.91	24,563,610.91
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,675,623.00	76,423,232.13	2,235,260,831.46	2,420,359,686.59

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	469,147,900.00	396,403,210.00	72,744,690.00	84.49
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	469,147,900.00	396,403,210.00	72,744,690.00	84.49
210	Бараа, үйлчилгээний зардал	469,147,900.00	396,403,210.00	72,744,690.00	84.49

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,814,400.00	257,413,232.00	43,401,168.00	85.57
210101	Үндсэн цалин	248,224,400.00	193,072,330.00	55,152,070.00	77.78
210102	Нэмэгдэл	49,033,900.00	51,202,500.00	(2,168,600.00)	104.42
210104	Урамшуулал	3,556,100.00	13,138,402.00	(9,582,302.00)	369.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,601,700.00	32,517,624.00	5,084,076.00	86.48
210201	Тэтгэврийн даатгал	25,569,200.00	21,868,245.00	3,700,955.00	85.53
210202	Тэтгэмжийн даатгал	3,008,100.00	2,662,295.00	345,805.00	88.50
210203	ҮОМШӨ ний даатгал	2,406,500.00	2,129,896.00	276,604.00	88.51
210204	Ажилгүйдлийн даатгал	601,600.00	532,398.00	69,202.00	88.50
210205	Эрүүл мэндийн даатгал	6,016,300.00	5,324,790.00	691,510.00	88.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,219,100.00	53,555,554.00	1,663,546.00	96.99
210301	Гэрэл цахилгаан	5,000,000.00	3,336,481.00	1,663,519.00	66.73
210302	Түлш, халаалт	48,719,100.00	48,719,073.00	27.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	55,941,800.00	34,551,900.00	21,389,900.00	61.76
210502	Хоол, хүнс	55,941,800.00	34,551,900.00	21,389,900.00	61.76
2106	Эд хогшил худалдан авах	4,080,000.00	4,080,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	4,080,000.00	4,080,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	962,000.00	315,000.00	647,000.00	32.74
210806	Мэдээллийн технологийн зардал	962,000.00	315,000.00	647,000.00	32.74
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	14,528,900.00	13,969,900.00	559,000.00	96.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,278,900.00	8,719,900.00	559,000.00	93.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,250,000.00	5,250,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	469,147,900.00	467,484,354.00	1,663,546.00	99.65
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	391,398,800.00	391,398,800.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	391,398,800.00	391,398,800.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	77,749,100.00	76,085,554.00	1,663,546.00	97.86
132001	Орон нутгийн төсвөөс	77,749,100.00	76,085,554.00	1,663,546.00	97.86
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	71,081,144.00	(71,081,144.00)	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь тухайн орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхэлж байна. Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд “Хүүхэд нэг бүрийг бүтээлч сэтгэлгээтэй уламжлалт ёс заншлаа дээдэлдэг эрүүл чийрэг бие бялдартай, эерэг харилцаатай хүн болгон төлөвшүүлэхэд гэр бүл олон нийтийн байгууллага эцэг эхийн оролцоог нэмэгдүүлнэ” гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд 7 зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Шинэ-Идэр сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, түүнийг 85 хувь биелүүлж ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна. Засгийн газар болон Боловсрол шинжлэх ухааны яамнаас дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:

1. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
2. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ” баталсан байна.
3. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
4. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны

12 дугаар сарын 20-ны өдрийн А/23 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 5 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,563.6 мянган төгрөгөөр өссөн байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	71,081.10	71,081.10
Авлага	0	1,350.60	1,350.60
Бараа материал	68,888.70	65382.7	-3,506.00
Үндсэн хөрөнгө	2,326,907.30	2282545.2	-44,362.10
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>2,395,796.0</u></b>	<b><u>2,420,359.6</u></b>	<b>24,563.6</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Төрийн өмч/	108675.6	108675.6	0
Хуримтлагдсан үр дүн	2210697.2	2235260.8	24563.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	76423.2	76,423.20	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b><u>2,395,796.0</u></b>	<b><u>2420359.6</u></b>	<b>24,563.6</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 71,081.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 3,506.0 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалын үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 44,362.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 14,635.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 58,997.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 406,186.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 56,913.8 мянган төгрөг, нийт 463,100.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүнг 58,836.5 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 58,836.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь орон нутгийн төсвөөс авах дүн нэмэгдсэн нь байгууллагын төрийн үйлчилгээний ажилчид цалин авах болсонтой холбоотой, улсын төсвөөс авах дүнг их хэмжээгээр бууруулсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба тайлант онд төрийн үйлчилгээний ажилчид орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжсэнтэй, мөн өргөн хэрэглээний бараа материалын үнэ өссөнтэй холбоотой Боловсрол Шинжлэх ухааны сайдын тушаалаар төсөвт 2 удаа зохицуулалт хийгдэж төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Тус өөрчлөлтүүдээр анх баталсан улсын төсвийг нийт 44,049.0

мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, орон нутгийн төсвийг 38,001.2 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Тус цэцэрлэг нь 2022 онд 150 хүүхдийн хүчин чадалтай ажиллаж нэг хүүхдийн нормоор тооцож авах санхүүжилт 384939,5 мянган төгрөг байх байтал, 391,398.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Тайлант онд 6,459.3 мянган төгрөгийн илүү санхүүжилт авсан нь төлөвлөлт үндэслэл муутай төлөвлөгдсөн байна.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан орон нутгийн төсвөөс баталсан төсвийг 38,001.2 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс санхүүжих дүнг 44,049.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 391,398.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 77,749.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 391,398.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 71,081.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 77,749.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 1,663.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 396,403.2 мянган төгрөг буюу 84.5 хувьтай байгаа нь Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвийг 47,231.2 мянган төгрөгөөр, Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардлын төсвийг 1,901.1 мянган төгрөгөөр, ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардлын төсвийг 1,663.5 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлын төсвийг 21,389.9 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн үйлчилгээний зардлын төсвийг 354.0 мянган төгрөгөөр, багшийн тасралтгүй хөгжлийн зардлын төсвийг 205.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардал	59,299.1	57,635.6	1,663.5	97,2
2	Нийтлэг үйлчилгээ	18,450.0	18,450.0	-	100
3	Эрүүл мэндийн үйлчилгээ	1,300.0	946.0	354.0	72,8
4	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	55,941.8	34,551.9	21,389.9	61,8
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,398.9	1,398.9	-	100
6	Багшийн тасралтгүй хөгжил	1,300.0	1,095.0	205.0	84,2
7	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	287,725.5	240,494.3	47,231.2	83,6
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	43,732.6	41,831.5	1,901.1	95,7
	<b>Нийт дүн</b>	<b>469,147.9</b>	<b>396,403.2</b>	<b>72,744.7</b>	<b>84.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус Хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Нью баланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нью-баланс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 400,392.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,007.8 мянган төгрөгөөр, мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (80 хувиар) буюу 6,406.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй зүйл илэрсэн болно. Үүнд: Тайлант онд түлш халаалтын зардлаас 500.0 мянган төгрөг түлээний үнэ гэж шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дах заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт нийт 148 мэдээлэл оруулахаас 4 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, 142 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.
2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад зарлагын 6,027.3 мянган төгрөгийн 1 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, 108,368.8 мянган төгрөгийн 5 мэдээлэл буруу дүнгээр мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулийн холбогдох заалт, 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн журам заавруудын хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчилтэй асуудал илэрч байна. Үүнд:

1. Эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэргүй 110.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 2 ширхэг үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

2. Бараа үйлчилгээний бусад зардлаас тээвэр шатахууны зардалд 2,088.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд зардлын бүлэг хооронд 10.5 мянган төгрөг тус тус гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1,300.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн ба биелэлт 50 хувь байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	2	1300.0	1	550.0	50
Нийт дүн	2	1300,0	1	550.0	50

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн 1,427.7 мянган төгрөгийн залруулга хийгдсэн болно. Аудитаар нийт 118,532.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> зөрчил<sup>2</sup> илэрснээс аудитын явцад 1,427.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож аудитын явцад төлөгдсөн, 114,396.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2,208.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 5.2 Албан шаардлага

Тус цэцэрлэг нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөмж авсан мөн тайлант онд хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, батлагдсан төсвийн мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,027.3 мянган төгрөгийн 1 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, 108,368.8 мянган төгрөгийн 5 мэдээлэл буруу дүнгээр мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **Илрүүлэлт:**

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. . .  
Үүнд:

1. 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 148 мэдээлэл оруулахаас 4 мэдээлэл хугацаа хоцроож, 142 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.
2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад зарлагын 6,027.3 мянган төгрөгийн 1 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, 108,368.8 мянган төгрөгийн 5 мэдээлэл буруу дүнгээр мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж хэвших

## **2. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Бараа үйлчилгээний бусад зардлаас тээвэр шатахууны зардалд 2,088.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд зардлын бүлэг хооронд 10.5 мянган төгрөг тус тус гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

### **Илрүүлэлт:**

Эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэргүй 110.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 2 ширхэг үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрээр үндсэн хөрөнгө данснаас хасах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүртгэлийн алдаа	2	1,427.7	0	0	0	0	2	1,427.7		0	0	0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,427.7</b>					<b>2</b>	<b>1,427.7</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг зориулалтаар нь зарцуулаагүй	2	2,098.6	0	0	0	0	1	2,098.6		0	0	0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,098.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>2,098.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	4	6,027.3	0	0	1	114,396.2	0	0
Буруу дүнгээр мэдээлсэн	5	108,368.8	0	0				0
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>114,396.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>114,396.2</b>	<b>0</b>	<b>0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Эрх бүхий байгууллагын шийдвэргүй үндсэн хөрөнгө акталсан	1	110.0	0	0	0	0	1	110.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>110.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>110.0</b>
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>114,506.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>114,396.2</b>	<b>1</b>	<b>110.0</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 1/1

Л.МАНДАХНАРАН ОГНОО:

Б.ЛХАГВАДОРЖ ОГНОО: 2023.02.16



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 16 өдөр

№ 02/А22260439/ХӨА-2023/14/НА -  
-ЛТЯ-ТНЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 1 гүйлгээ хугацаа хоцроосон, орлогын 5 гүйлгээг буруу дүнгээр мэдээлсэн 114,386,184.00 (нэг зуун арван дөрвөн сая гурван зуун наян зургаан мянга нэг зуун наян дөрвөн) төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй байна.
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 8 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинэ Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Амарбаясгалан, нягтлан бодогч П.Энхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Д.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

 Д.ГЭРЭЛЧУЛУУН

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043


**2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**

Байгууллагын нэр: Шинэ-Идэр сумын Хүүхдийн  
Тайлант хугацаа: 2022 он

№	Ажил үйлчилгээний анги, дансны үлдэгдэл тодруулга	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өсөн харуу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
A		2	3	4	5	6	7	8	9
1	210302	Нэгдсэн халаалтанд холбогдсон халаалтын мөнгө сард 6,027,384 төгрөг Дулаан эрдэнэт ОНӨААҮГ төлдөг байтал ганцхан 12 сард нярав Ү. Шагдарсүрэнд 500,000 төгрөгөөр түлээ худалдаж авч өгөөд шууд зарлагдсан байна.	500,000	Төлбөрийн акт тогтоох	Гэнэт тог тасарсан үед хуучин цэцэрлэгийн байранд хүүхдийнхээ хоол хийхэд зарцуулах зорилгоор 500,0 төгрөгний түлээ нөөцөлж авдаг. Үүний 250.0 төгрөгийг шилдэг багш ажилтан, аймгийн аварга багшийг шагнаж урамшуулах төсөв байхгүй тул зарцуулсан алдаа гаргасан. Байгууллагад портор түлээ нөөцөд байгаа. Түлээний мөнгө дахиж гаргаж өөр зүйл рүү зарцуулахгүй байхыг бүр мөсөн таслан зогсооно.	Аудитын явцад төлж барагдуулах	2023 оны 02 дугаар сарын 15 нд Хө Бусад нэр заагдаагүй орлого Төрийн сан банкны 1001700009 55 тоот дансанд төлсөн.	Эрхлэгч Ня-бо	Р.Амарбаясгалан П.Энхбаяр
3	210101	ЕЖ, МГЖ-аар цалин нь цалин цэсээрх цалингаас 1,350,636 төгрөгөөр зөрүүтэй байна.	1,350,636	Залруулах Ажиллагсадтай холбогдсон авлага ДТ - 1350636, Үндсэн цалин КТ-1350636	3.4 сард тохируулга мэдээг гаргачихаад хянаагүй орхигдуулснаас зөрүү үүсгэсэн. Дахин ийм зөрчил үүсгэхгүй анхаарч ажиллая.	Залруулах	Залруулах	Эрхлэгч Ня-бо	Р.Амарбаясгалан П.Энхбаяр
4	210101	Цалингийн зардлаас 10,591 төгрөгийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал руу зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.	10,591	Зөвлөмж өгөх	Зардал хооронд гүйлгээ зарцуулсан алдаа гаргасан байгаа тул дахин ийм зөрчил гаргахгүй тал дээр анхаарч ажиллана.	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Эрхлэгч Ня-бо	Р.Амарбаясгалан П.Энхбаяр

сая төгрөгөөр

5	21090102	Бараа үйлчилгээний бусад зардлаас автомашингүй байж зориулалт бусаар шатахууны зардалд 2,088,120 төгрөг зарцуулсан байна.	2,088,120	Албан шаардлага хүргүүлэх	Байгууллагын хог ачих, багш ажилчид сургалтанд явах зэрэгт шатахууныг шаардах хуудсаар олгож зарцуулж ирсэн.сумын жолооч нар байгууллагын хүмүүсийг мөрөн авч явахдаа дургүй албан хүчээр шахуу шатахууны бичиг өгч хүмүүсээ явуулдаг гэрээ хийх гэхээр хийдэггүй хэцүү байдаг	Албан шаардлага хүргүүлэх <i>Зөвлөлт өгөх</i>	Албан шаардлага хүргүүлэх <i>Зөвлөлт өгөх</i>	Эрхлэгч Ня-бо	Р.Амарбаясгалан П.Энхбаяр
9	210502	Хоол хүнсний зардлаас тайлант онд 34,629,050 төгрөгийн хүнсний материал худалдан аваад 34,551,900 төгрөгийг шилжүүлсэн байна. Зөрүү 77,150 төгрөгийн материалыг нярав У.Шагдарсүрэнгээс орлого авсан ч НББ-д өглөг үүсгээгүй байна.	77,150	Залруулах /Хүнсний материал ДТ-77150,Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого КТ-77150/	хандивын орлогыг өөрийн орлогоор бүртгэж алдаа гарсныг дахин давтаж гаргахгүй талаар анхаарч ажиллана	Залруулах	Залруулах	Эрхлэгч Ня-бо	Р.Амарбаясгалан П.Энхбаяр
10	39207	110,000 төгрөгийн анхны өртөгтэй 2ш үндсэн хөрөнгийг сумын ИТХ-ын шийдвэргүй актлах тушаал шийдвэргүй актлж устгасан байна	110,000	Зөвлөмж өгөх	Ийм зөрчлийг давтан гаргахгүй үндсэн хөрөнгийг сумын ИТХ-аар актлуулж хууль журмын дагуу ажиллана	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Эрхлэгч Ня-бо	Р.Амарбаясгалан П.Энхбаяр
12	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл зохих 148 мэдээллээс 4 мэдээлэл хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын1 гүйлтээ хугацаа хоцроосон, орлогын 5 гүйлтээ буруу дүнгээр мэдээлсэн байна. <b>НЬЮ БЭЙНЭС АУДИТ ХХК</b>	114,396,184	Албан шаардлага хүргүүлэх	Шилэн дансны болон цахим хуудасны мэдээллийг нөхөж хийж биш хугацаа хугацаанд нь хийж байршуулах тал дээр нягтлан бодогчид хяналт тавьж шахаж шаардаж ажиллаагүйгээс ийм алдаа гаргасан гэж үзэж байгаа тул цаашид зөрчил дутагдал гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллана.	Албан шаардлага хүргүүлэх	Албан шаардлага хүргүүлэх	Эрхлэгч Ня-бо	Р.Амарбаясгалан П.Энхбаяр



Хүлээн зөвшөөрсөн: Эрхлэгч  
Нягтлан бодогч  
Р.Амарбаясгалан  
П.Энхбаяр

Бэлтгэсэн: Аудитор  
Хянасан: Захирал  
Д.Гэрэлчулуун Огноо:  
Б.Лхагвадорж Огноо:



Нийт зөрчлийн дүн

118,532,681

## МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ / MONEY TRANSFER

Хүлээн авагчийн /Beneficiary's:

Он/ҮҮ Сар/ММ Өдөр/DD

2023...02...15


Банкны нэр / Bank name:	Дансны № / Account No:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
ТӨРИЙН САП	100170000955	Хө.Бусад нэр заагдаагүй орлого
Мөнгөн дүн тоогоор/ Amount: 500,000.00	Мөнгөн дүн үсгээр/ Amount in words: Таван зуун мянган тэгрэг	Валют/ Currency: MNT
Гүйлгээний утга, бусад тэмдэглэл/ Details of payment:		Нууц код/ Code:
ШИЛЭ-ИДЭР ЦЭЦЭРЛЭГ ПЯ-БО ЭНХБЯАР ТОЛБОРИЙН АКТ		

Шилжүүлэгчийн / Sender's

Банкны нэр/ Bank name:	Дансны №/ Account No:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
ТӨРИЙН БАНК	20002485	ЛХАГВАДОРЖ РЮ59040861 99101901
Мөнгөн дүн тоогоор/ Amount: 500,000.00	Валют/ Currency: MNT	Гүйлгээний төрөл/ Transaction type Банк хоорондын бэлэн гүйлгээ-13600506
Харилцагчийн тэмдэглэл/ Customer note:		

Тамга/ Stamp:


Баталгаат гарын үсэг/ Authorized signature:



2

3

Банкны тэмдэглэгээ/ For bank use only:

Теллер №	Журнал №	Огноо	Гүйлгээний хураамж	Шилжүүлэгчийн биеийн байцаалтын төрөл №	Теллер гарын үсэг
8229/2000	844690663743	2023.02.15 11:48	500.00		

БАТЛАВ.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

2023 оны дугаар сарын

## МЭДЭГДЭЛ

Шинэ Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Р.Амарбаясгалан-д

### Сонсох ажиллагаа явуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 21.1."Шалгагдагч этгээд захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасны дагуу Шинэ Идэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчилд албан шаардлага өгөх болсон тул Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 17.30 цагт сонсох ажиллагаа явуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонсох ажиллагаа нь дараах дарааллаар явагдана. Үүнд:

1. Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг танилцуулах;
2. Захиргааны шийдвэр гаргах асуудлын талаарх үндэслэл, шалтгаан нөхцөлийг танилцуулах;
3. Санал сонсох.

Мэдэгдлийг гардуулж өгсөн:

Гэрээт аудитор Д.Гэрэлчулуун / Д.Гэрэлчулуун/  
албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг хүлээн авсан:

Эрхлэгч Р.Амарбаясгалан / Р.Амарбаясгалан /  
Нягтлан бодогч П.Энхбаяр / П.Энхбаяр /  
албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг гардуулж өгсөн огноо: 2023.02.06

**СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

№ \_\_\_\_\_

2023 оны 02-р сарын 07-ны өдөр

Мөрөн сум хот

Захиргааны ерөнхий хуулийн дагуу Шинэ Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Р.Амарбаясгалан, нягтлан бодогч П.Энхбаяртай 2023 оны 02дугаар сарын 07-ны өдрийн 17.30 цагт Ньюбаланс аудит ХХК-ны албан өрөөнд биечлэн уулзах хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагыг төлөөлж: Аудитор Д.Гэрэлчулуун

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх:

Татгалзаж байгаа шалтгаан: \_\_\_\_\_ гарын үсэг \_\_\_\_\_

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна. Гарын үсэг \_\_\_\_\_

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэл, мэдээллийг Шинэ Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Р.Амарбаясгалан, нягтлан бодогч П.Энхбаяр нарт танилцуулав.

Асуулт, хариулт:

Нэгдсэн халаалтанд холбогдсон халаалтын мөнгө сард 6,027,384 төгрөг Дулаан эрдэнэт ОНӨААҮГ төлдөг байтал ганцхан 12 сард нярав Ё. Шагдарсүрэнд 500,000 төгрөгөөр түлээ худалдаж авч өгөөд шууд зарлагадсан байна.

Гэнэт тог тасарсан үед хуучин цэцэрлэгийн байранд хүүхдийнхээ хоол хийхэд зарцуулах зорилгоор 500.0 төгрөгний түлээ нөөцөлж авдаг. Үүний 250.0 төгрөгийг шилдэг багш ажилтан, аймгийн аварга багшийг шагнаж урамшуулах төсөв байхгүй тул зарцуулсан алдаа гаргасан. Байгууллагад портор түлээ нөөцөд байгаа. Түлээний мөнгө дахиж гаргаж өөр зүйл рүү зарцуулахгүй байхыг бүр мөсөн таслан зогсооно.

Асуулт, хариулт

Бараа үйлчилгээний бусад зардлаас автомашингүй байж зориулалт бусаар шатахууны зардалд 2,088,120 төгрөг зарцуулсан байна.

Байгууллагын хог ачих, багш ажилчид сургалтанд явах зэрэгт шатахууныг шаардах хуудсаар олгож зарцуулж ирсэн. Суманд жолооч нар өдөрт 1 машин явдагжолоочтой гэрээ хийх боломгүй 1 хүний зардал 20000төг төлөөд үүнээс 10 хувийн татвар авах гэхээр татвараа төлөхгүй бичиг баримт бүрдүүлэх гэхээр уурлаж авч явах дургүй замынхаа хүнийг аваад явах нь дээр гэдэг.

Асуулт, хариулт

2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлвэл зохих 148 мэдээллээс 4 мэдээлэл хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 1 гүйлгээ хугацаа хоцроосон, орлогын 5 гүйлгээ буруу дүнгээр мэдээлсэн байна.

Шилэн дансны болон цахим хуудасны мэдээллийг нөхөж хийх биш хугацаа хугацаанд нь хийж байршуулах тал дээр нягтлан бодогчид хяналт тавьж шахаж шаардаж ажиллаагүйгээс ийм алдаа гаргасан гэж үзэж байгаа тул цаашид зөрчил дутагдал гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллана.

Асуулт, хариулт

Тайлант онд ур чадварын нэмэгдэл цалин 43,335.50 төгрөг, балансын урамшуулал 910,161 төгрөг, нийт 953,496.5 төгрөгийн цалин илүү олгосон байна.

Хууль дүрэм журмын дагуу цалин урамшууллыг олгож хууль дүрэм журмаа сайтар уншиж санхүүгийн мэдээллээр хангаж ажиллан дахин зөрчил гаргахгүй ажиллана зөрчилгүй дүгнэлт авсан тул няравын балансын шагналыг анх удаа олгосон тул няравыг актаас чөлөөлж өгнө үү

Ямар нэгэн тайлбар санал байна уу?

Нягтлан бодогч М.Цэвэлмаа:

Байхгүй

Сонсох ажиллагааг 17:35 цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл:

Оролцогч:



/ Д.Гэрэлчулуун /

Р.Амарбаясгалан/

/П.Энхбаяр/